

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	18
Аудитын зөвлөмж	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	21
4. Менежментийн захидал	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭНГЭЛ ТАНАА

2021.02.25 № 07/595
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн болон орон нутгийн өмчит 6082 хуулийн этгээдийн төрийн өмчийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих үндсэн үүрэг хүлээж ажилладаг. Төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн асуудлыг судлан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд дээрх мэдээллийг хамруулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,043,845,013.13	556,154,745.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,043,845,013.13	434,440,092.13
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,043,845,013.13	434,440,092.13
31210	Төгрөг	1,043,845,013.13	434,440,092.13
31211	Төрийн сангийн харилцах	1,043,845,013.13	434,440,092.13
33	АВЛАГА	-	117,970,073.07
33500	Бусад авлага	-	117,970,073.07
33510	Байгууллагаас авах авлага	-	117,970,073.07
35	БАРАА МАТЕРИАЛ	-	3,744,580.00
35400	Хангамжийн материал	-	3,744,580.00
35410	Бичиг хэргийн материал	-	2,610,680.00
35470	Бусад хангамжийн материал	-	1,133,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,058,557,109.88	3,037,822,634.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,058,557,109.88	3,037,822,634.11
39200	Биет хөрөнгө	3,527,624,709.88	2,953,102,234.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,026,142,380.00	2,751,191,680.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,344,622.16)	(132,813,067.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	954,256,805.51	122,648,620.57
39204	Хуримтлагдсан элэгдэл	(727,923,151.66)	(46,200,511.87)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	553,249,049.02	364,129,969.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(315,325,037.88)	(181,608,684.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	377,981,267.20	297,884,779.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(269,411,980.15)	(222,130,550.34)
39300	Биет бус хөрөнгө	1,530,932,400.00	84,720,400.00
39301	Програм хангамж	1,495,962,000.00	49,750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,960,400.00	35,960,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,102,402,123.01	3,593,977,379.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,043,845,013.13	435,372,664.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,043,845,013.13	435,372,664.13
41300	Өглөг	1,043,845,013.13	435,372,664.13
41360	Бусад өглөг	1,043,845,013.13	435,372,664.13
41361	Байгууллагад төлөх өглөг	1,043,845,013.13	434,440,092.13
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	932,572.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,058,557,109.88	3,158,604,715.18
51	Засгийн газрын хувь оролцоо	5,058,557,109.88	3,158,604,715.18
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	35,655,560.00	35,655,560.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,624,835,014.93	2,724,882,620.23
51210	Өмнөх үеийн үр дүн	4,867,628,726.59	4,624,835,014.93
51220	Тайлант үеийн үр дүн	(242,793,711.66)	(1,899,952,394.70)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,066,534.95	398,066,534.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,102,402,123.01	3,593,977,379.31

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	159,970,612,430.35	174,992,607,244.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,380,516,530.35	173,657,881,644.69
120	Нийтлэг татварын бус орлого	157,946,162,701.79	173,212,259,484.69
120001	Хувьцааны ногдол ашиг	155,232,194,792.89	170,552,803,838.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,409,275.49	23,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,409,275.49	23,000,000.00
120005	Түрээсийн орлого	2,384,772,879.20	2,472,052,275.52
120009	Бусад орлого	-	31,813,974.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	270,785,754.21	132,589,396.27
121	Хөрөнгийн орлого	434,353,828.56	445,622,160.00
121002	Өмч хувьчлалын орлого	434,353,828.56	445,622,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,590,095,900.00	1,334,725,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,469,095,900.00	1,249,725,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,469,095,900.00	1,249,725,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,000,000.00	85,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	121,000,000.00	85,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	159,909,863,498.31	174,940,938,159.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,909,863,498.31	174,940,938,159.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,712,410,898.54	1,124,509,943.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	899,686,299.12	705,650,140.17
210101	Үндсэн цалин	680,730,900.00	516,660,400.00
210102	Нэмэгдэл	165,049,899.12	162,111,350.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,905,500.00	26,878,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,214,254.69	42,118,413.49
210201	Тэтгэврийн даатгал	76,473,300.00	29,021,857.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,750,354.69	3,326,890.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,197,500.00	2,605,189.52
210204	Ажилгүйдлийн даатгал	1,799,400.00	651,299.61
210205	Эрүүл мэндийн даатгал	17,993,700.00	6,513,176.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,841,217.20	-
210301	Гэрэл, цахилгаан	4,873,700.00	-
210302	Түлш, халаалт	2,967,517.20	-
2104	Хангамж, бараа материалын зардал	67,520,289.19	30,272,740.00
210401	Бичиг хэрэг	25,316,600.00	9,786,940.00
210402	Тээвэр, шатахуун	12,929,500.00	7,414,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,586,299.19	5,140,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,687,890.00	7,931,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,804,600.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,538,600.00	-
210604	Урсгал засвар	5,266,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	42,687,726.00	2,978,800.00
210702	Дотоод албан томилолт	42,687,726.00	2,978,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	327,452,689.17	142,529,263.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	306,982,062.17	119,396,147.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	537,040.00	-

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,760.00	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,178,827.00	21,513,115.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,203,823.17	200,960,585.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,967,001.00	722,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	209,236,822.17	200,238,485.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,197,452,599.77	173,816,428,216.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,417,808.00	100,373,280.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	82,417,808.00	8,269,280.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	92,104,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	158,115,034,791.77	173,716,054,936.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,693,108.32	245,576,662.68
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,182.80	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	158,051,321,500.65	173,470,478,273.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	60,748,932.04	51,669,085.08
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	303,542,643.70	1,951,621,479.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	303,542,643.70	1,951,621,479.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(242,793,711.66)	(1,899,952,394.70)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	159,755,632,163.15	174,860,017,848.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,165,536,263.15	173,525,292,248.42
120	Нийтлэг татварын бус орлого	157,731,182,434.59	173,079,670,088.42
120001	Хувьцааны ногдол ашиг	155,232,194,792.89	170,552,803,838.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,409,275.49	23,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,409,275.49	23,000,000.00
120005	Түрээсийн орлого	2,384,772,879.20	2,472,052,275.52
120009	Бусад орлого	55,805,487.01	31,813,974.50
121	Хөрөнгийн орлого	434,353,828.56	445,622,160.00
121002	Өмч хувьчлалын орлого	434,353,828.56	445,622,160.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,590,095,900.00	1,334,725,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,469,095,900.00	1,249,725,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,469,095,900.00	1,249,725,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,000,000.00	85,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	121,000,000.00	85,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,700,626,676.14	175,469,422,769.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,700,626,676.14	175,469,422,769.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,503,174,076.37	1,652,994,552.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	899,686,299.12	705,650,140.17
210101	Үндсэн цалин	680,730,900.00	516,660,400.00
210102	Нэмэгдэл	165,049,899.12	162,111,350.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,905,500.00	26,878,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,214,254.69	42,118,413.49
210201	Тэтгэврийн даатгал	76,473,300.00	29,021,857.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,750,354.69	3,326,890.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,197,500.00	2,605,189.52
210204	Ажилгүйдлийн даатгал	1,799,400.00	651,299.61
210205	Эрүүл мэндийн даатгал	17,993,700.00	6,513,176.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,841,217.20	-
210301	Гэрэл, цахилгаан	4,873,700.00	-
210302	Түлш, халаалт	2,967,517.20	-
2104	Хангамж, бараа материалын зардал	65,742,389.19	31,680,940.00
210401	Бичиг хэрэг	25,316,600.00	8,809,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,929,500.00	7,414,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,586,299.19	5,140,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,909,990.00	10,317,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,858,600.00	85,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,538,600.00	85,000,000.00
210604	Урсгал засвар	5,320,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	42,687,726.00	2,978,800.00
210702	Дотоод албан томилолт	42,687,726.00	2,978,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	329,176,589.17	143,620,263.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	307,951,962.17	121,896,147.98

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	537,040.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	254,760.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	120,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,932,827.00	20,104,115.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,967,001.00	641,945,995.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	641,223,895.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,967,001.00	722,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,197,452,599.77	173,816,428,216.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,417,808.00	100,373,280.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	82,417,808.00	8,269,280.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	92,104,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	158,115,034,791.77	173,716,054,936.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,693,108.32	245,576,662.68
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,182.80	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	158,051,321,500.65	173,470,478,273.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	55,005,487.01	(609,404,921.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	55,005,487.01	(609,404,921.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	988,839,526.12	1,043,845,013.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,043,845,013.13	434,440,092.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,571,402,126.59	5,005,124,221.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	296,226,600.00	296,226,600.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,867,628,726.59	5,301,350,821.54
Тайлант үеийн үр дүн	-	-	(242,793,711.66)	(242,793,711.66)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,624,835,014.93	5,058,557,109.88
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,624,835,014.93	5,058,557,109.88
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,624,835,014.93	5,058,557,109.88
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,899,952,394.70)	(1,899,952,394.70)
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	2,724,882,620.23	3,158,604,715.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,254,725,600.00	1,027,143,937.32	-	81.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,254,725,600.00	1,027,143,937.32	-	81.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,154,304,500.00	926,770,657.32	-	80.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,086,800.00	705,650,140.17	-	81.95
210101	Үндсэн цалин	615,499,700.00	516,660,400.00	-	83.94
210102	Нэмэгдэл	171,955,100.00	162,111,350.17	-	94.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,632,000.00	26,878,390.00	-	36.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,040,400.00	42,118,413.49	-	37.59
210201	Тэтгэврийн даатгал	82,204,900.00	29,021,857.76	-	35.30
210202	Тэтгэмжийн даатгал	7,458,800.00	3,326,890.13	-	44.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,967,100.00	2,605,189.52	-	43.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,491,800.00	651,299.61	-	43.66
210205	Эрүүл мэндийн даатгал	14,917,800.00	6,513,176.47	-	43.66
2104	Хангамж, бараа материалын зардал	31,690,000.00	31,680,940.00	-	99.97
210401	Бичиг хэрэг	8,817,600.00	8,809,000.00	-	99.90
210402	Тээвэр, шатахуун	7,414,300.00	7,414,300.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,140,400.00	5,140,400.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,317,700.00	10,317,240.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,978,800.00	2,978,800.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	2,978,800.00	2,978,800.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,786,400.00	143,620,263.66	-	98.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,759,500.00	121,896,147.98	-	98.49
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	-	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,106,900.00	20,104,115.68	-	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	722,100.00	722,100.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	722,100.00	722,100.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,421,100.00	100,373,280.00	-	99.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,421,100.00	100,373,280.00	-	99.95

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,317,100.00	8,269,280.00	-	99.43
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	92,104,000.00	92,104,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,254,725,600.00	1,027,143,937.32	222,581,662.68	81.86
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,249,725,600.00	1,004,143,937.32	245,581,662.68	80.35
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,249,725,600.00	1,004,143,937.32	245,581,662.68	80.35
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	23,000,000.00	(23,000,000.00)	460.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	23,000,000.00	(23,000,000.00)	460.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	1,043,845,013.13	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	434,440,092.13	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	111.00	111.00	111.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55.00	55.00	55.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	47.00	47.00	47.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	7.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55.00	55.00	55.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	48.00	48.00	48.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	7.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	-
I	ОРЛОГЫН ДҮН		85,000,000.00
	Төсвийн урамшуулал		85,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	85,000,000.00
	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		85,000,000.00
	1. Бараа, ажил үйлчилгээний зардал		85,000,000.00
	1.2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		-
	1.3. Бараа үйлчилгээний бусад зардал		-
	Гэрэл, цахилгаан		-
	Түлш, халаалт		-
	Эд хогшил, урсгал засварын зардал		85,000,000.00
	Татаас бусад урсгал шилжүүлэг		-
	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал		-
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		-
	Мөнгөн хөрөнгийн 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын дарга Б.Цэнгэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага, өр төлбөрийг тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах, төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөж ажиллах, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа хуульд заасан журмын дагуу ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газар ахлах аудитор Б.Энхжин, аудитор Э.Бүгүнүтэй, Ж.Нямцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар /Аудитын хоёрдугаар газар/-т 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А-1/79 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг тодорхой болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргах зорилт дэвшүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохицуулалтаар хангах,
- Төрийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих,
- Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа тул санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 175,057,646.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,750,576.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,627,159.0 мянган төгрөгөөр буюу 57.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,043,845.0	434,440.1	(609,404.9)
Байгууллагаас авах авлага	-	117,970.1	117,970.1
Бараа материал	-	3,744.6	3,744.6
Үндсэн хөрөнгө	5,058,557.1	3,037,822.6	(2,020,734.5)
Нийт хөрөнгө	6,102,402.1	3,593,977.4	(2,508,424.7)
Өр төлбөр	1,043,845.0	435,372.7	(608,472.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,058,557.1	3,158,604.7	(1,899,952.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,102,402.1	3,593,977.4	(2,508,424.7)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 434,440.1 мянган төгрөг болж 609,404.9 мянган төгрөгөөр буурсан нь "Төрийн өөрийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын дагуу иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан эд хөрөнгө түрээслүүлэх гэрээний дагуу байршуулсан өмнөх онуудын барьцаа хөрөнгийг чөлөөлснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,744.6 мянган төгрөг болж өссөн нь хангамжийн материалын өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,037,822.6 мянган төгрөг болж 2,020,734.5 мянган төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 438 дугаар “Агентлаг байгуулах тухай” тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газрыг байгуулсантай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын балансад бүртгэлтэй 1,884,030.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн,
- Өмнөх оны аудитын албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуваарилах зорилгоор эзэмшиж байсан автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор бусад байгууллагын балансад 595,480.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 435,372.7 мянган төгрөг болж, 608,472.3 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийг түрээсэлж буй иргэн, аж ахуй нэгжийн түрээсийн барьцаа хөрөнгө чөлөөлснөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,158,604.7 мянган төгрөг болж 1,899,952.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нийт 2,020,734.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу бусад байгууллагын балансад шилжүүлж, хуримтлагдсан үр дүн буурсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 15,087,033.5 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг өмнөх оноос 15,320,609.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотойгоор нийт орлого 15,087,033.5 мянган төгрөгөөр, нийт зардал 15,130,236.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,732,435.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,732,435.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,477,710.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,254,725.6 мянган төгрөгөөр баталсан нь Төрийн худалдан авах ажиллагааны газар байгуулагдсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,249,725.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,249,725.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 23,000.0 мянган төгрөг, нийт 1,272,725.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,027,143.9 мянган төгрөгийг зарцуулж, 245,581.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,027,143.9 мянган төгрөг буюу 81.9 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 155,436.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 69,921.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тайлант онд 174,440,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 173,470,478.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган
төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашиг	172,940,000.0	170,552,803.8	(2,387,196.2)	98.6
Төрийн өмчийн түрээсийн орлого	1,500,000.0	2,472,052.3	972,052.3	164.8
Өмч хувьчлалын орлого	-	445,622.2	445,622.2	
Нийт дүн	174,440,000.0	173,470,478.3	(969,521.9)	99.4

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 315 дугаар тогтоолоор Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс 173,693,030.0 мянган төгрөгийг улсын төсөвт тогтсон байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 315 дугаар тогтоолоор баталсан Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашгийг "Эрдэнэс Монгол" ХХК 2,037,813.2 мянган төгрөгөөр "Улаанбаатар Төмөр зам" ХНН 1,137,200.0 мянган төгрөгөөр, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК 543,273.1 мянган төгрөгөөр, "Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв" ТӨҮГ 19,216.7 мянган төгрөгийг тус тус дутуу төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Сангийн сайдын 2020 оны 225 тоот тушаалаар төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос 85,000.0 мянган төгрөгийн зарцуулах эрх олгож, үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 124 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож 25 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 109,742.6 мянган төгрөгийн 5 ажил гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8,340,437.5 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 595,480.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 346,611.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн. Үүнээс төлбөрийн акт 53.3 хувь, албан шаардлага 80 хувь, зөвлөмж 64 хувийн биелэлттэй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,400,666.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 284,538.3 мянган төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 4,116,128.2 мянган төгрөгийн зөрчлөөс 3,737,503.0 акт тогтоож, 288,878.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 89,747.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 284,538.3 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны эцэст 2,980.4 мянган төгрөгөөр бараа материалын үлдэгдлийг шууд зардлаар тайлагнасан,
2. 85,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үндсэн хөрөнгийн орлогод аваагүй, шууд зардлаар бүртгэсэн,
3. Автотээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 47,634.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
